



АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 09 сарын 23 өдөр

Дугаар A/76

Улаанбаатар хот

Амгалан дулааны станц ХХК-ийн
сургалтын хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Компанийн дүрмийн 6.9.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Амгалан дулааны станц ХХК-ийн Сургалтын хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Амгалан дулааны станц ХХК-ийн Сургалтын хөтөлбөрийг үе шатны дагуу зохион байгуулахыг Сургалт, судалгааны мэргэжилтэн С.Байгалмаад үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтсийн дарга Б.Ган-очирт үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Ш.БАЯНМӨНХ

Амгалан дулааны станц ХХК-ийн
Гүйцэтгэх захирлын 2019 оны 09 дүгээр сарын
13-ны өдрийн 4/26 дугаар тушаалын хавсралт



АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ХХК-ИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР /2019-2021/

АГУУЛГА

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Сургалтын хөтөлбөр боловсруулах хууль, эрх зүйн шаардлага
- 1.2 Ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх шаардлага
- 1.3 Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа

ХОЁР. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

- 2.1 Хөтөлбөрийн зорилго
- 2.2 Хөтөлбөрийн зорилт

ГУРАВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, ҮР ДҮН

- 3.1. Зорилтын хүрээнд 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа
- 3.2. Зорилтын хүрээнд 2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа
- 3.3. Зорилтын хүрээнд 2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа
- 3.4. Хөтөлбөрийн үр дүн

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

- 4.1.Хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр

ТАВ. АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦЫН СУРГАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

- 5.1 Сургалтын 2018-2019 оны явцын талаарх тоо баримт
- 5.2 Компанийн ажилтнуудын мэдлэг боловсрол, 2018 онд сургалт хамрагдсан байдалд хийсэн “SWOT” шинжилгээ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Сургалтын хөтөлбөр боловсруулах хууль, эрх зүйн шаардлага

Тус компанийн ажилтнуудыг дараах хууль, дүрэм, журмын шаардлагаар сургах, дадлагажуулах зорилгоор энэхүү хөтөлбөрийг боловсруулав. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хууль
2. ХАБЭА-н тухай хууль
3. Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 325 дугаар тогтоол, Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны үндэсний хөтөлбөр (2018-2023)
4. Эрчим хүчний ажилтны дунд зохиох аюулгүй ажиллагааны үндсэн дүрэм
5. Нэгдсэн сүлжээний дүрэм
6. Даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм
7. Уурын ба усан халаалтын зуухыг төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрэм
8. Уур халуун усны шугам хоолойг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм
9. Ачаа өргөх краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм
10. Цахилгаан станц, дулааны шугам сүлжээний дулаан-механикийн тоноглолын ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааны дүрэм
11. Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм
12. Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм
13. Эрчим хүчний салбарын ажиллагсдыг сургах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах журам
14. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах, шалгалт авах журам
15. Компанийн Хөдөлмөрийн дотоод журам
16. Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх, гэрчилгээ олгох журам
17. Хүний нөөцийн бодлого, хамтын ажиллагаа-2018 зөвлөгөөнөөс гаргасан чиглэл, шийдвэр
18. Бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам

1.2 Ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх шаардлага

Ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх дараах шаардлага үүссэн. Үүнд:

- 1.2.1 Ижил төстэй техник-технологитой дулааны станц Монгол Улсад байхгүй тул туршлага судлах бололцоо байхгүй.
- 1.2.2 ЭХХТ-ийн Эрчим хүчний сургалтын төвд зөвхөн цахилгаан станцын зуухны машинчийн сургалт болдог тул манай зуухны машинчийг тусгайлсан хөтөлбөрөөр бэлтгэх шаардлага үүссэн.
- 1.2.3 Нийт 181 ажилтнуудын 74% нь 40 хүртэлх насны залуу боловсон хүчин байгаа учир тэдэнд мэргэжил олгох, ажилд богино хугацаанд дадлагажуулах шаардлагатай.
- 1.2.4 Нийт ажилтнуудын 18,2% буюу 33 ажилтан өөрийн ажлын байрны тодорхойлолт, тариф мэргэжлийн шаардлагад нийцсэн мэргэжил боловсрол эзэмшээгүй.

- 1.2.5 Тус станц нь байгуулагдаад удаагүй учир сургалтын тогтолцоог бүрдүүлэх дүрэм, журам шаардлагатай байгаа.

1.3 Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа:

Хөтөлбөрийг 2019-2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

ХОЁР. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

2.1. Хөтөлбөрийн зорилго

Компанийн эрхэм зорилгыг ханган биелүүлэх зорилгоор ажилтнуудыг сургах, сургалтын тогтолцоог бүрдүүлэх, сургалтын чанар, өгөөжийг нэмэгдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2 Хөтөлбөрийн зорилт

- 2.2.1 Эрчим хүчний мэргэжилгүй ажилтнуудыг ажлын байрны тодорхойлолт, тариф мэргэжлийн лавлахад заасан эрчим хүчний мэргэжил эзэмшүүлэх сургалтанд хамруулах
- 2.2.2 Эрчим хүчний салбарт мөрдөгддөг дүрэм, журмын шаардлага, ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх шаардлагаар ажилтнуудыг давтан сургалтанд хамруулах
- 2.2.3 Сургалтын тогтолцоог бүрдүүлэх
- 2.2.4 Ажилтнуудыг гадаад, дотоодын ижил төстэй үйлдвэр, аж ахуйн газруудаас туршлага судлах ажлыг зохион байгуулах
- 2.2.5 Инженер техникийн ажилтан, мэргэжилтнийг мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулах
- 2.2.6 Мэргэжилтэй ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх зорилгоор ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулах
- 2.2.7 Сургалтын материаллаг баазыг бэхжүүлж, сургалтын таатай орчин бүрдүүлэх

ГУРАВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, ҮР ДҮН

3.1 Дэвшүүлсэн зорилтын хүрээнд 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 3.1.1 Эрчим хүчний мэргэжилгүй нийт ажилтнуудын 50-иас доошгүй хувийг ЭХХТ-ийн Эрчим хүчний сургалтын төвд сургаж, ажлын байрны тодорхойлолт, тариф мэргэжлийн лавлахад заасан мэргэжлээр эрчим хүчний мэргэжил эзэмшүүлэх
- 3.1.2 Эрчим хүчний системд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дүрэм, журмын шаардлагаар мэргэжлийн үнэмлэхний хугацаа дуусах дөхсөн эрхтэй ажилтнуудыг давтан сургалтанд хамруулж, үнэмлэхжүүлэх
- 3.1.3 Удирдлага, инженер техникийн ажилтныг гадаад, дотоодын дулаан үйлдвэрлэгдчийн туршлага судлах ажлыг зохион байгуулах
- 3.1.4 Станцын сургалтын үйл ажиллагааг зохицуулах хөтөлбөр, журам боловсруулах

- 3.1.5 Цех, хэсгийн удирдлага, инженер техникийн ажилтнуудтай хамтран тариф мэргэжлийн лавлах мөрдөн ажиллах ажлын байрны дагалдан суралцах хөтөлбөрийг шинэчлэх
- 3.1.6 Техникийн номын фондыг үүсгэх

3.2 Дэвшүүлсэн зорилтын хүрээнд 2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 3.2.1 Эрчим хүчний мэргэжилгүй ажилтнуудын 90-ээс доошгүй хувийг ЭХХТ-ЭХСТ-д мэргэжил эзэмшүүлэх сургалтанд хамруулж эрчим хүчний мэргэжилтэй болгох
- 3.2.2 Эрчим хүчний системд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дүрэм, журмын шаардлагаар мэргэжлийн үнэмлэхний хугацаа дуусах дөхсөн эрхтэй ажилтнуудыг давтан сургалтанд хамруулж, үнэмлэхжүүлэх
- 3.2.3 Инженер техникийн ажилтан, мэргэжилтнийг гадаад хэлний мэдлэгийн түвшинг дээшлүүлэх зорилгоор гадаад хэлний сургалт зохион байгуулах
- 3.2.4 Инженер техникийн ажилтныг удирдах арга барил, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон заах арга зүйн ур чадварыг дээшлүүлэх сургалтуудад хамруулах
- 3.2.5 Цех, хэсгийн удирдлага, инженер техникийн ажилтантай хамтран засварчдын дунд ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулах
- 3.2.6 Цех, хэсгийн удирдлага, инженер техникийн ажилтантай хамтран ашиглалтын ээлжүүдийн дунд ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулах
- 3.2.7 Цех, хэсгийн удирдлага, инженер техникийн ажилтантай хамтран мэргэжилтэй ажилтнуудын дунд мэдлэг сорих ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулах
- 3.2.8 Удирдлага, инженер техникийн ажилтан, мэргэжилтэн, ажилчдыг гадаад, дотоодын дулаан үйлдвэрлэгчдийн туршлага судлах ажлыг зохион байгуулах
- 3.2.9 Цех, хэсгийн удирдлага, инженер техникийн ажилтнуудтай хамтран тариф мэргэжлийн лавлах мөрдөн ажиллах ажлын байрны дагалдан суралцах хөтөлбөрийг шинэчлэх
- 3.2.10 Мэргэжлийн мэдлэгийн шалгалтын журмыг шинэчлэн боловсруулах

3.3 Дэвшүүлсэн зорилтын хүрээнд 2021 онд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

- 3.3.1 Сургалтын танхимтай болох
- 3.3.2 Сургалтын танхимыг шаардлагатай техник хэрэгслээр тоноглох
- 3.3.3 Мэргэжлийн ном, хууль, дүрэм, журам, ашиглалтын заавраар эмхэтгэлийн бааз бүрдүүлж, цахим хэлбэрт шилжүүлэх
- 3.3.4 Эрчим хүчний системд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дүрэм, журмын шаардлагаар мэргэжлийн үнэмлэхний хугацаа дуусах дөхсөн эрхтэй ажилтнуудыг давтан сургалтанд хамруулж, үнэмлэхжүүлэх
- 3.3.5 Удирдлага, инженер техникийн ажилтан, ажилчдыг гадаад, дотоодын дулаан үйлдвэрлэгчдийн туршлага судлах ажлыг зохион байгуулах
- 3.3.6 Тариф мэргэжлийн лавлах мөрдөн ажилладаг ажилтныг ахисан түвшний сургалтанд хамруулах

3.4 Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

- 3.4.1 Эрчим хүчний салбарт мөрдөгддөг хууль, дүрэм, журам зөрчигдөх нөхцөл арилах
- 3.4.2 Эрчим хүчний мэргэжилгүй ажилтны 90-ээс доошгүй хувь нь ажлын байрны тодорхойлолт, тариф мэргэжлийн лавлахад заасан мэргэжил эзэмшсэн байх
- 3.4.3 Амгалан дулааны станцад тохирсон сургалтын тогтолцоо бүрдсэнээр сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө оновчтой болсон байх
- 3.4.4 Ажилтны мэргэжлийн ур чадвар дээшилж, мэргэжлийн алдаа дутагдал эрс цөөрсөн байх
- 3.4.5 Сургалтын материаллаг бааз бүрдэж, сургалтын таатай орчин бүрдсэн байх

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

4.1. Хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр

Хөтөлбөр нь дараах санхүүжилтийн эх үүсвэртэй байна. Үүнд:

- 4.1.1. Компанийн зардалаар
- 4.1.2. Олон улсын төсөл, хөтөлбөрөөр

Хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг компанийн жил бүрийн зардалын төлөвлөгөөнд тусган зарцуулна.

Тайлбар: Амгалан дулааны станцыг 50 МВт-аар өргөтгөж, дулаан цахилган хослон үйлдвэрлэдэг станц болгон өөрчилсөн тохиолдолд сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулна.